



# ЛАМ НАРЫН СЭТГҮҮЛ

2011 он. № 1 (5)

СУВДАН  
СОНДОРЫН  
ГУРВАН ХҮЙС

MONGOLIAN BUDDHISM

PAST  
PRESENT

БУРХАНЫ

ИМЧИД  
НОР  
БАСАГИЙНСҮР  
СҮРЭНМОНГОЧУР  
ХӨӨРЛӨБАЙ



# ЛАМ НАРЫН

2011.07 сар, дугаар 05 СЭТГҮҮЛ

Шинжлэх ухаан, танин мэдэхийн сэргүүл  
МУИС-ийн Шашин судалын тэхникийн хэвлэл

## РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ:

### ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:

ГАНТУЯА Гүнзэг Магсаржавын

доктор, МУИС, НШУС, Шашин

судалын тэхникийн эрхэлч

### НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

ЯНЖИНСҮРЭН Хансан Содномдоржийн

доктор, МУИС, НШУС, ШСТ

### ГИШҮҮД:

ЧОЙЖАМЦ Бөхөл Дэмбэрэллийн  
гаек, МБШТСЕ Гандантэгээнлийн хийдийн  
Тэргүүн, Их Хамба лам

ДАМБАЖАВ Чойжилжавын  
Дашчойлин хийдийн Хамба лам

БАТАЙХАН Эмгээн Оохний  
тухийн шинжлэх ухааны доктор, профессор,  
ШУА-ийн Олон Улсын судалын хурээлэнд ЭША

БОЛДБААТАР Боржигон-Тавт Жижидийн  
академик МУИС, НШУС, Туухийн судалгааны  
хурээлэнчин захирал

БУЛГАН Намнан Түмээхүүгин  
гаек, доктор, АБАТХ-ын Ерөнхий нарийн  
бичгийн дарга

ЛОНЖИД Харнууд Зоригтын  
тухийн шинжлэх ухааны доктор, МУИС,  
НШУС, Туухийн тэнхим

СОНИНБАЯР Боржигон Шагдарсурэнгийн  
гаек, доктор, профессор, Гандантэгээнлийн  
хийдийн Эрээмсэгийн хурээлэнчин захирал

ЦЭДЭНДАМБА Халзан Самдангийн  
доктор, профессор, МУИС, НШУС, ШСТЭХИМ

ЭНХТӨР Элхийн Дамбийханчангийн  
гаек, МУИС, НШУС, ШСТЭХИМ

ПҮРЭВДОРЖ Шарнууд Лувсандаагын  
Монголын Бурханы шашины хөгжүүлэх  
санжин Тэргүүн

ДАВААЖАВ Их Монгол Равхирин  
[www.mongolian-buddhism.mn](http://www.mongolian-buddhism.mn), сайт эрхлээц

### ЕРӨНХИЙ РЕДАКТОР М.ГАНТУЯА

Ерөнхий продюсер Л.ПУРЭВДОРЖ

Хариуцлагатай нарийн бичгийн дарга

Бэсүд Сүхбаатарын ДЭМБЭРЭЛ

Жавсан Мандширийн МӨНХБАТ

Менежмент, зийн засалын албан Л.ПУРЭВДОРЖ

Дизайн ба арт редактор Мандширийн МӨНХБАТ

Донж, цахим уралт М.Мөнхбат

Сурталчилгааны мэջжэр А.Алтанхуяг

Гэрэл зургуудыг Жавсан М.Мөнхбат

И.Р.Даваажав

# LAMAS JOURNAL

Popular Science journal  
Publication of the Department of Religion Studies  
of SSS NUM

### CHIEF-IN-EDITOR GANTUYA.M

Executive Editors

DEMBEREL Besud Sukhbaataryn

MUNKHBAT Jaysan Mandshiryn

Managing Director Purevdorj,L

Design & Art Director Munkhbat.M

Design & Layout Munkhbat.M

Advertising manager Altankhuuyag.A

### BOARD OF ADVISERS:

PRESIDENT: GANTUYA Gingege Magsarjavyn  
PhD, Department of Religion Studies  
(DRS), SSS NUM

VICE PRESIDENT:  
YANJINSUREN Khansan Sodnomdorjin  
PhD, DRS, SSS NUM



LAMAS JOURNAL

## Редакторын зурвас

**M**анай сэтгүүлийн редакцийн зөвлөлийн гишүүд бид эрхэм ушигч та бүхийхээ амар амгаланг эрэн мэндчилж байна. Бид энэ удаагийн дугаартаа, ХХ зууны, тэр дундаа 1990 оны Ардчилсан хувьсгалаас хойш Бурханы шашины дахин сэргэсэн, дэлгэрсэн түүхэнд хамрах сэдвээрх өгүүлэл, нийтлэлүүдийг эмхлэн хургэхийг хичээв.

1990 оны цагаагчин морин жилийг "Сайн цагийн эхэн" хэмээн хутагт хувилгаад бошиглосончлон, хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн, хүмүүнлэг ардчилсан нийгмийг, морин жилийн тасхийм хүйтэн жаврыг сөрөн байж авчиралцсан Баасан ламттан, коммунист дарангуйлын түнэр он жилүүдэд бурхан шашин, өв соёл, олон мянганд сорчлон туурvigдсан эрдэм ухааны охио сэтгэлдээ тээж, итгэлдээ бататган эдүгээ цагийн бидэнд өртөөлөн хургэсэн эрдэмт мэргэн лам хувраг, өвөг дээдэс, номт багши нараа эрхгүй санагалаз.

Цагийн эргэлтэд хахилзуулан байсан эх түүх, уламжлалт шашин минь энэ цаг дор дахин сэргэж дэлгэрэхдээ, балчир хуухэд хөлд орохдоо бүдэрдэгийн адил алдаа оноо бүхнийг өөртөө агуулсан байх авай. Хэдий тийм ч Бурхан багшийн айлдсанчлан, Бурханы сургаал умраас умарт түгэж, Цогт Наландрын хир угүй ариун ёс Монгол орноо дэлгэрч байгаа энэ таатай цаг дор зөвхөн лам хуврагууд төдийгүй эрдэмтэн судлаачид, багши мэргэдийн оруулах хувь нэмэр цаглашгүй билээ.

Хувь ихт, заяа төгөлдөр монгол түмний минь билиг оюуны мэлмий тунгалаг, өлмий бат орших болтугай.

### Хариуцлагатай нарийн бичгийн дарга Ж.М.Мөнхбат

**ADVISERS BOARD:** Ven.CHOIJAMTS Bokhol Demberel (gabju, Khanbo lama of Gandan Tekchenling Monastery, Head of Center of Mongolian Buddhists); Ven.DAMBAJAB Choijiljavyn (Khanbo lama Tashi Choeeling monastery); BATSAIKHAN Emgent Ookhnoin (SD, prof. Head of Russian Department, Institute of International studies of MAS); BOLDBAATAR Bonogon-Tavt Jigidyn (Academician, Director of Institute of the History, SSS NUM); Ven.BULGAN Namnan Tumeekhnuugyn (gabju, PhD, General Secretary of ABCP); LONJID Kharnuud Zorigtyn (SD, Department of History SSS NUM); Ven.SONINBAYAR Boljilgon Shagdar-surenbyng (gabju, PhD, prof. Director of Institute of Culture and Education at the Gandan Tekchenling monastery); TSEDENDAMBA Khaizan Samdangsyn (PhD, prof. DRS, SSS NUM); ENKHTOR Eljigen Dambijantsangyn (geshe, DRS, SSS NUM, PUREWDORJ Sharniuud Luvsandagyn (Head of the Foundation for Preservation of the Mongolian Buddhism); DAWAAJAV Ih Mongol Rayjiryn (Director of site [www.mongolian-buddhism.mn](http://www.mongolian-buddhism.mn))

tel: (976)-70113159, mobile: (976)-99113159, fax: (976)-70113160; add: Гандантэгчийн хийд, 8 тахил дэлгүүр;





web: <http://mongolian-buddhism.mn>; email: journalformonks@mongol.net; lovon8@yahoo.com;

messenger: journalformonks@yahoo.com; post: Ulaanbaatar-46A/545, Mongolia.

Хөвтсэнсүүлэх Төвхөн хийд, зурагийг Л.Элбэгзаяа

Гуулда нийтлэгдсэн гучуулгүй зураг, бусад материалыг редакцийн албан ёсны бичгэн зөвшөрлгүйгээр бүрэн болон хэсэгчилсэн хэлбэрээр дахин хэвлэхийг хориглоно. Реклам, зар сурталчилгааны үзүүн бодот залдлыг редакц хариуцагчийг All rights reserved. Copyright © Lamas Journal 2011. Мөнхийн усаг" компанийд хавалз. 2011 он. Printed in company "Munkhii Useg" Mongolia.

- 81–87 СҮМ ХИЙДЭД ШАВИЛАН СУУЖ БАЙГАА  
ХҮҮХДИЙН СУРАХ ЭРХИЙН АСУУДАЛ
- 88 С.ДУЛАМ, АРВАН УХААНД ХАЙЛСАН ИХ БАГШ
- 89–94 С.ДУЛАМ, БАГШААС ДАМЖСАН ТОГТСОН  
ТААЛЛЫН СУРГААЛ
- 95–135 ТЕЛЕКИ КРИСТИНА, 1937 ОНД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАРИМ СҮМ ДУГАНЫ ТОГТМОЛ  
ХУРЛУУДЫН ЖАГСААЛТ
- 136–143 Ш.БОЛД, МОНГОЛ ЭРДЭМТЭД ТӨВД  
ЭМНЭЛЭГТ ХИЙСЭН ШИНЭЧЛЭЛ
- 144–149 Г.БИЛГҮҮДЭЙ, «МОНГОЛЫН НУУЦ  
ТОВЧООН»-Ы ЭХИЙН 12 БА 15 БҮЛЭГТ БОЛОН  
ХУУЛАГДСАН УЧИР
- 150–156 З.ОЮУНБИЛЭГ, ТӨВХӨН ХИЙД
- 157–161 Н.АМГАЛАН, ЛЕНИНГРАД ДАХЬ БУДДЫН  
СҮМИЙН ТУХАЙ
- 162–166 А.ЭРДЭНЭСАЙХАН, АЛАГШАА АГВААНДАНДАР  
ЛХАРАМБЫН НАМТАР БҮТЭЭЛИЙН ЗАРИМ  
АСУУДАЛД



- 167–171 Ж.ЛХАГВАДЭМЧИГ, ЭНЭ НАС ХИЙГЭЭД ХОЙД  
НАСАНД ХЭРХЭН АЗ ЖАРГАЛТАЙ БАЙХ ВЭ?
- 172–177 Н.НАРАНГЭРЭЛ, ГҮР ДУУНЫ ОНЦЛОГ ШИНЖ
- 178–180 Г.АМАРСАЙХАН, ШАРЫН ШАШНЫ НӨЛӨӨН  
ДООРХИ МОНГОЛЫН ОДОН ОРОН ЗУРХАЙ  
СУДЛАЛ
- 181–188 Ш.ЧУЛУУНБААТАР, МИНИЙ МЭДЭХ ОЮУТАН,  
УМЗАД, ГЭЛЭН, АРДЧИЛАГЧ БААСАН ЛАМ
- 189–194 Д.СҮХБААТАР, МОНГОЛЫН БУРХНЫ ШАШНЫ  
СЭРГЭЛТ
- 195–196 Ц.ЭРДЭНЭБАТ, «МОНГОЛ НОГООН ДАРА  
ЭХИЙН ТУУЖ» НОМЫН ТУХАЙД УТГЫГ  
ХУРААЖ ӨГҮҮЛЭХ НЬ
- 197–198 Б.ОДГЭРЭЛ, БИДНИЙ ИХЭНХ НЬ «ҮХЭХГҮЙ  
ХҮМҮҮС»
- 199–200 ДАШЧОЙЛИН ХИЙДЭД ХҮРЭЭ ЦАМ ГАРАВ

# 1937 онд Улаанбаатар хотын зарим сүм дуганы тогтмол хурлуудын жагсаалт

1996-2002 онд БНУУ-ын "Eötvös Loránd" их сургуулийн Төв-Азийн тэнхимд төвд-монгол хэл соёлын ангийг магистр зэрэгтэй дүүргэсэн. 2009 онд "Bogdii Khüree: Monasteries and Temples of the Mongolian Capital (Монголын нийслэл, Богдын хүрээний сүм хийдүүд) (1651-1938)" сэдвээр докторын зэрэг хамгаалсан. 1999 оноос Монголд урт болон богино хугацаагаар 8 удаа ирж, "Монголын сүм хийдийн түүхэн товчоон" төсөлд Majer Zsuzsa монгол судлаачтай цуг хот, хөдөөгүйн сүм хийдийн судалгаа, буддын шашин судлал, 2010 онд Заяа гэгээндийн хүрээний түүх, Позднеевийн 1892-1893 хооронд аялсан замаар судалгаа шинжилгээний ажил хийсэн. 2011 оноос "Eötvös Loránd" их сургуулийн Төв-Азийн тэнхимийн судлаачаар ажиллааж байна.

**Телеки КРИСТИНА**



neris ğerge-yi nigečü dutaydayulal ügei-ber uul  
jokiqa asayulta-yin yosuyar todorqayilan büridgekü  
küsünög-tü).

Тус хүснэгт нь 1937 оны 9 сарын 22-28-ны хооронд дахь тогтмол хурлуудыг монгол бичгээр тэмдэглэсэн бололтой. Тэдгээр асуултын хуудсуудыг чухамдаа ямар зорилгоор, хэн хэн бөглөсөн гэдэг нь тодорхойгүй. Бөглөсөн хүмүүс нь хурлуудын нэрс мэддэг (нярав лам нар байсан байж магадгүй), харин хүснэгтэд тэмдэглэгдсэн зүйлс үнэн бодитойг нь нотлоход хэцүү. Гэвч Монголын шашин шашны 300-аад жилийн түүхэнд хурсан хурлуудтай холбоотой хамгийн дэлгэрэнгүй мэдээлэл багтсан учир энэ сурвалжийг үнэлэх, мэдэх, судлах хэрэгтэй юм. Үүний нэгэн адил хүснэгтүүдийг тухайн үеийн шашны захиргаанд хамарагддаг байсан бүх сүм хийдүүдэд бөглүүлсэн атал, архивийн баримтуудад нийслэл хотын 28 сүм хийдийн хүснэгт байхаас бус, харин бусад дансуудад одоогийн байдлаар тохиолдсонгүй. Энэхүү хүснэгтийн доторхи асуултууд бараг ижилхэн. Үүнд:

- Дэс дугаар (mo. des duyar)
- Ямар дацан аймаг ба хийд сүм болохын нэр (mo. yamar dačang aimay ba keyed süm-e bolqu-yin ner-e)
- Ямар нэртэй тогтмол хурал уншлага гүрэм

1990 оноос хойш дахин сэргээсэн болон тинээр байгуулсан сүм хийдүүдэд шарын ба улан ёсны лам хуврагууд хамаг амьтны тусын түүл олон тооны хурал хурж байна. Үүн дотроо хамгийн олон ном хурдаг нь Гандан, Зүүн гэрээ-Дашчойлин хийдүүд юм.

1937 он хүртэл хөдөө, хотын сүм хийд дурануудад лам нар нилээд олон хурал хурдаг байжээ. Зарим нь тогтмол хурал, зарим нь хандагуудаас хамаарсан хурал байдаг байв. Жилийн хамгийн том дүйцэн өдрүүдийн тухай (Майдар эргэх, Цам харайх) гэрэл зургууд бий. Харин сүм дугануудад ямар ямар хурал хурдаг байсан тухай түүхэн сурвалж бичгүүд тун ховор үзжээ.

Монголын Үндэсний Архивын "орчин үеийн" сан хөмрөг (1921-1940)-т хурлуудын тухай чухал сурвалж хадгалагдаж байна. Энэ үе Шашны захиргааны хүснэлтээр бөглүүлсэн хүснэгт юм. Энэхүү сурвалжийн гарчиг нь Гандан хүрээн дэхь шашны захиргааны харьят багтаж захирагдсан олон дацан аймаг хийд сүмүүдийн дор бүрийн нэг жилд тогтмол хурдаг хурлуудын нэрс зэргийг нэг чуутагдуулалгүйгээр уул зохих асуултын ёсоор тодорхойлон бүртгэх хүснэгт" (мо. Gangdang ᠬүүен-deki šasin-u jakiryan-u qariya-tu baytaju aktuudyasan olan dačang ayimay keyed süm-e-lerin nigenjil-dü toytamal qurday qural-ud-un

зэргүүд болохын нэрс (мо. yamar ner-e-tei toytamal qural ungsily-a gürüm ğerge-üd bolqu-yin neres)

- Эдгээр хурлууд жил бүр хэдэн сарын хэднээс эхлэн хэдэн хоногийн хугацаатай болохыг дэлгэрэнгүй бичмой (мо. edegeq qural-ud jil büri kedün sar-a-yin kedün-eče ekilen kedün qonoq-un quyučaγ-a-tai bolqu-yi delgerenggүi bičimüi)
- Эдгээр хурлуудад тус бүр хичнээн лам хурваас зохих (мо. edegeq qural-ud-du tus büri kečinen lama qurabasu jokiqu)
- Түүнд хурсан лам нар хичнээн болох (мо. (t) egün-dü quraysan lam-nar kečinen bolqu)
- Огт хурж чадал угүй тасарсан хурал буй эсэх буй ахул ямар шалтгаан учраас болсныг бичмой (мо. oytu quražu čidal-a ügei tasuraysan qural bui esekü bui aqul-a yamar siltayān učir-ača boluysan-i bičimüi)

Хүснэгтэд 28 сүм хийдийн нийлээд 622 тооны хурлууд тэмдэглэгдсэн байна. Хурлуудын он сар өдрөөс гадна, мөн хүлээж байсан, хуралд ирсэн лам нарын тоо, заримдаа хурал хурах зорилгыг хүртэл бичжээ. Иймийн учир 1937 онд Улаанбаатар хотод байсан шарын ёсны дугануудын идэвхтэй үйл ажиллагаа, лам нарын тоо тун тодорхой бичигдэж үлдجээ. Үүнээс гадна зарим хурлыг хурахгүй болсон шалтгаанаас харвал тухайн үеийн улс төрийн үйл явдлыг мэдэхэд түлхэц болохуйц баримт юм. Энэхүү хүснэгтийг 1937 оны 9 сарын сүүл хүртэлхи хурсан хурлууд, мөн хуралд оролцсон лам нарын тоо тодорхой байгаа боловч түүнээс хойш бичигдсэн хурлуудыг хурсан болон хуралд оролцсон лам нарын тоо бичигдээгүй учраас хойшхи хурлуудын талаархи мэдээлэл байхгүй.

#### Уг 28 сүм хийд нь:

##### ГАНДАН:

- Гандантэгчэлийн ба З шарилын сүм (нийлээд 31 хурал, МҮҮТА: X196/1/8)
- Гүнгаачойлин дацан (42 хурал, X-188/1/144)
- Идгаачойнзинлийн дацан (35 хурал, X-189/1/2)
- Хайлан жас (3 хурал, X-189/1/135)

##### ЗҮҮН ХҮРЭЭ:

- Эмч нарын дацан (17 хурал, X-193/1/42)

#### 21 АЙМГИЙН ДУГАН:

- Жадарын аймаг (10 хурал, X-201/1/58)
- Тойсамлин аймаг (23 хурал, X-216/1/44)
- Цэцэн тойны аймаг (23 хурал, X-206/1/37)
- Дашиандарлин аймаг (16 хурал, X-220/1/44)
- Жасын аймаг (20 хурал, X-204/1)
- Номчийн аймаг (15 хурал, X-207/1/23)
- Сангайн аймаг (16 хурал, X-205/1/79)
- Зоогийн аймаг (29 хурал, X-209/1/66)
- Дугарын аймаг (14 хурал, X-208/1/73)
- Мэргэн хамбын аймаг (12 хурал, X-218/1/18)
- Бизъяагийн аймаг (11 хурал, X-198/1/23)
- Хүүхэн ноёны аймаг (10 хурал, X-221/1/26)
- Дархан эмчийн аймаг (16 хурал, X-214/1/19)
- Эрхэм тойны аймаг (23 хурал, X-227/1/48)
- Вангайн аймаг (48 хурал, X-200/1/21)
- Баргын аймаг (7 хурал, X-199/1/55)
- Намдолингийн аймаг (26 хурал, X-212/1/38)
- Бандидын аймаг (13 хурал, X-197/1/12)
- Сүнгийн аймаг (25 хурал, X-211/1/18)
- Лам нарын аймаг (17 хурал, X-215/1)
- Мэргэн номуун ханы аймаг (15 хурал, X-210/1/36)
- Өрлүүдийн аймаг (25 хурал, X-224/1/9)

**ДАМБАДАРЖАА** хийдийн (X-240/1/2) Цогчин дуган, Мамба дацан, Цанид дацан, Дүйнхор дацан ба б аймгийн тогтмол хурлуудын нийлүүлээд 90 нэрс бичигдсэн байна.

Тэмдэглэгдсэн нийт хурлуудын тоо болох 622 бол харьцангуй тоо болно. Учир нь зарим номуудыг жилд олон удаа (Жишээлбэл: сарын дүйцэн өдрүүд, улирлын хурлууд) хурдаж байсан учир 622-оос ч илүү олон удаа хурах боломжтой.

Хамгийн идэвхтэй үйл ажиллагаа явуулж байсан дугануудад 90 хуралтай Дамбадаржaa хийд, 48 хуралтай Вангайн аймгийг дурдаж болохоор байна.

Хүснэгтийг худам монголоор бичсэн бөгөөд хурлуудын нэрсийн ихэнх нь төвд гаралтай учир зарим нэгэн төвд эх ба орчин цагийн нэр томьёог тогтоож чадсангүй. Иймийн учир (?) тэмдэгээр тэмдэглэв. Өөрийн диссертацид англи

хэлэр энэхүү жагсаалтын тухай дэлгэрэнгүй тайлбарласан учир энэ удаа хурж байсан хурлуудын зарим хэсгээс товчлон дурдлаа. (*Тус судлаагааг Унгар улсын "OTKA PD 83465" иеээн тэтгэсэн*)

Өдөр бүрийн Цогчин хурлыг Цогчин дугануудад хурах ба дацан, аймгийн дугануудад тодорхой тоо бүхий лам нар (2,4,8 гэх мэт) тухайн дуганы уншлага, ядам сахиуснуудтай холбоотой Жасаа хурлыг хурна. Жишээ нь: Жасаа сахиус, Жасаа Пагам, Жасаа Лхам, Жасаа Маналын бумба.

Гол төлөв чойр дацанггуудад тус дацанггуудын бүх лам нар оролцож томоохон Жасаа хурлуудыг хурдаг байжээ. Жишээ нь: Жасаа Ганжуур, Жасаа Авидын дончид, Жасаа Сарын хурал, Жасаа Хорны хурал.

Сан уншлагыг зарим үед даллагатай, зарим үед дорвултэй хурдаг байв.

Зүүн хүрээний Цогчин дуганы хүснэгт одоогоор олдоогүй учир Жамбын чого, Майдар эргэх, Жахар цам, Бурхан багшийн өдрүүдийн тухай дэлгэрэнгүй мэдээ үгүй. Шашныг баригч дээдсүүдийн дүйцэн өдрүүд (Богд лам, Өндөр тэгээн Занабазар, Богдууд)-ийг олон дуганд тэмдэглэдэг байжээ. Эдгээр хурлын нэрийг зарим үед Дүйцэн (тө. *dus-chen*), заримдаа Дайчид, дайчод (тө. 'das-mchod) гэж бичсэн учир уг сурвалжид тэмдэглэснийг баримтлав. Өндөр тэгээн Занабазарын дүйцэн өдрийг одоо ч гэсэн хаврын эхэн сарын 14-нд тэмдэглэдэг, харин Хүрээнд түүний хойд дүрүүдийн ерөөлүүдийг уншдаг байжээ. 2-р Богдын дүйцэн ерөөл нь өвлийн сүүл сарын 17, 3-р Богдын дүйцэн ерөөл нь намрын сүүл сарын 21, 4-р Богдын дүйцэн ерөөл нь өвлийн дунд сарын 16, 5-р Богдын дүйцэн ерөөл нь өвлийн эхэн сарын 3, 6-р Богдын дүйцэн ерөөл нь өвлийн тэргүүн сарын 20, 7-р Богдын дүйцэн ерөөл нь өвлийн дунд сарын 12, 8-р Богдын дүйцэн ерөөл нь зуны тэргүүн сарын 17-нд одоо Ганданд хурж байна. Хачин багш, Жалханз хутагт, Ёнзон хамбын дүйцэн өдрүүдийг бас дурджээ.

Сахиусны хэд хэдэн янзын хурал байв. Зарим үед Сахиус ба Хангал хурал тус тусдаа бичигдсэнээс гадна, 10 хангал, 9 хангал, 6 хангал аль эсвэл 2 (Гонгор, Намсрай) буюу 1-ийт хурдаг байсан тохиолдолыг бичин Үдээсэн байна. Зарим үед данрагтай буюу дүгжүүтэй. Даншигын хангалыг өвлийн дунд сард олон аймагт хурдаг байжээ. Сүм хийдүүд

өөр өөрсдийнхөө сахиусууд (Шанлан, Таван хан, Их сахиус, Дэргэдийн хангал, Түмэд хангал гэх мэт)-ыг хурдаг байв. Мөн хуучин хурлуудаа сүм хийдүүд өөр өөр дэг жаягаар хурна. Зарим хэсэг нь 3 хоног, нөгөө хэсэг нь 1 хоногоор ч хурна. Харин битүүнд Цэдэр Лхамыг бүх хүрээ хийдүүд, сүм дуганууд хурна. Сахиуснуудтай холбоотой сахиус даллага, сахиусны үндэс, тахилга, сахиусны дордов/дордүүв сахиусны нямба, сахиусны түгдам/түгдэм/түгдүн гэх мэтчилэн олон төрлийн хурал хурдаг байжээ. Ядамууд (Жанрайсэг, Дарь эх, Чойнсүрэн Жидар буюу Жадар, Гүргүл, Бизъяа)-тай холбоотой хурлууд мөн адил олон янз байлаа. Зарим сүм дуганд Дүлцон элсэн мандалыг бүтээдэг байв. Жишээ нь: Дарь эх, Жанрайсэг, Пагам, Гүнрэг, (Дорж) Намжом, Манал.

45 хоногтой яр хайлэн, Сожин, Даш сожин сахилтай лам нар сахилаа баталж 3-15 хоногоор Нүннай/Нүгнээ/Нүгнэй сахьдаг байжээ. Жишээ нь: Жанрайсэгийн нүннай, Вачирваан (Очириваань)-ийн нүннай, Минтугвийн нүннай, Дөрвөн цагийн нүннай, Жасаа нүннай.

Олон дуганд 2-4 лам өвлийн сүүл сарын 24, 25 буюу 26-нд жасыг арвижуулахын үүднээс Жасын галын тахил(га) өргөдөг байв.

Гандантэгчэлийн хийдэд Сандуйн хурлыг монгол хэлээр хурахаас гадна сар бүрийн 10-нд 5 болон 7-р Богдын шарилын сүмүүдэд Хажидын хурал хурж, мөн Жүд буюу Үндэсийг (тө. *rgyud*) олон сүм дуганд бүрэн эхээр, зарим дуганд 1-р Далай лам (тө. *dge 'dun grub*)-ын хурлыг тус тус хурдаг байсан.

Бумбын тахилга, Ганжуур, Цогчид, Дончид, Бүтээл, Гүрэм гэх мэтчилэн хурлууд эдүгээ ч хурсаар л байна. Үүнээс гадна Чойрын дацанггуудын их, бага домууд, гавжийн дамчаа, (Парчин) Домын дамчаа, өвлийн хурал (тө. *dgun chos chen mo*), 30 ба 20 хоногтой хурлуудыг дурдах нь зүйтэй юм.

Цаашдаа одоогоор олдоогүй байгаа 9 аймаг, Гандангийн өөр бусад дацанггуудын үүнтэй адил хүснэгт олдвоос Хүрээний шарын шашны дугануудыг хаахаас өмнөх үеийн хурал номын үйл ажиллагааны талаар улам тодорхой болох юм. Мөн үүнээс гадна өндөр настай лам нарын яриа болон цаст төвдийн шарын шашныг хооронд нь харьцуулан үзвэл Монголын шарын шашны онцлог нь ихээхэн тодорхой болно хэмээн бодож байна.

	хурлын нэрс	тогтмол хурлын сар өдөр	эдгээр хурлуудад тус бүр хичнээн лам хурваас зохих	хурсан лам нарьн тоо	тасарсан хурал ба хурлын учир шалтгаан
<b>Гандантэгчэнлин</b>					
1.	Цогчин ба Мандалшиваа	өдөр бүр хурдаг	24	10	
2.	сангийн даамал: уншлага	өдөр бүр хурдаг	1	1	
3.	сангийн тахилч: уншлага	өдөр бүр хурдаг	1	1	
4.	Хангал	сар бүрийн шинийн 8	28	28	
5.	5-р богдын суварганд: Хажид	сар бүрийн 10	4	4	
6.	7-р богдын суварганд: Хажид	сар бүрийн 10	4	4	
7.	7-р богдын суварганд: Данжин	сар бүрийн 12	5	5	
8.	Цогчид	сар бүрийн 15	24	11	
9.	5-р богдын суварганд: Түй	сар бүрийн шинийн 3	2	2	
10.	5 орны: Түй	сар бүрийн 15	5	5	
11.	8-р богдын суварганд: Сандуй	сар бүрийн 17	4	4	
12.	5-р богдын суварганд: Дэмчиг	сар бүрийн 25	5	5	
13.	5-р богдын суварганд: Гомбо хурахад	өвлийн сүүл сарын 25	12	12	
14.	Цогчид	мөн сарын 27	24	9	
15.	3 суварганд цоржимд (?): Мандал өргөх	хаврын тэргүүн сарын 1-нд	14	14	
16.	Ерөөл маань Манал хурахад	мөн сарын 1-нээс эхлэн 15 хүртэл	24	24	
17.	Гандантэгчэнлинд ханбо (?): Майдар залж Ерөөл хурахад	мөн сарын 16-нд	гавж нар бүгд хурахаас	78	
18.	7-р богдын суварганд: Дамжин хурахад	мөн сарын 17-нд	12	12	
19.	Нүннайн хурахад	мөн хаврын сүүл сарын 30-аас эхлэн зуны тэргүүн сарын 16 хүртэл	4	4	
20.	8-р богдын суварганд: Цогчид	мөн сарын 17-нд	1	1	
21.	Жанрайсэгийн дүлцон	мөн сарын 17-оос эхлэн 30 дуустал	10	10	
22.	дудбунг (?) чамарадагва (?) хурахад	зуны сүүл сарын 4-нд	гавж нар бүгд гарахаас	42	
23.	8-р богдын суварганд: Түнлх хурахад	намрын сүүл сарын шинийн 8			
24.	бага Манал хурахад	мөн сарын 22-нд			

25.	5-р бодын суварганд: Цогчид өргөхөд	өвлийн тэргүүн сарын 3-нд			
26.	Цогчид өргөхөд	мөн сарын 3-нд			
27.	монгол Сандуй хурахад	мен сарын 25-нд			
28.	Цогчид өргөхөд	мөн сарын 25-нд			
29.	Цогчид өргөхөд	өвлийн дунд сарын 7-нд			
30.	монгол Сандуй хурахад	өвлийн дунд сарын 7-нд			
31.	7-р бодын суварганд: Цогчид өргөхөд	мөн сарын 12-нд			
<b>Гүнгаачайлийн дацан</b>					
1.	Гүнчойчэнмогийн хурал уншлага	өвлийн дунд сарын шинийн 17-оос эхлэн 30 хоногийн хугацаатай хурал	олноор	515	Их жас гүйцэтгэмий
2.	мөн хурлын дотор Парчин домын дамжаа суух	мөн 21-ний өдрөөс эхлэн 6 хоног	олноор	600	мөн жас
3.	жасаа Цэдэрлхамын уншлага	сар бүрийн шинийн 1-нд	100	91	Цэдэрлхамын жас
4.	жасаа Сахиусны уншлага	өдөр бүр	8	8	Их жас
5.	жасаа Цэдэвийн уншлага	өдөр бүр	8	8	мөн Их жас
6.	жасаа Дүдвийн уншлага	өдөр бүр	4	4	Их жас гүйцэтгэмий
7.	жасаа дөрөвт хэмээх Сахиусны	сар бүрийн шинийн 2-нд	4	4	Цэдэрлхамын жас гүйцэтгэмий
8.	жасаа наймт хэмээх Сахиусны уншлага	сар бүрийн 15-нд	8	8	мөн Цэдэрлхам жас
9.	жасаа Дүдвий	өвлийн сүүл сарын 25-нд	олноор	25	Их жас хурдаг
10.	жасын галын тахилга	өвлийн сүүл сарын 25-нд	2	2	мөн Их
11.	жасын уншлага Чойжин Гүргүүл Дарь эхийн бүтээл	өдөр бүр	3	3	мөн Их
12.	Хуучин ном хэмээх Сахиус	өвлийн сүүл сарын 29-нд	100	35	мөн Их
13.	Цагаан сарын дүдва хэмээх уншлага	хаврын тэргүүн сарын шинийн нэгнээс эхлэн 15 хоногт	олноор	205	Дүдвийн жас гүйцэтгэмий
14.	Гавжийн дамжаа суух	хаврын тэргүүн сарын 16-аас эхлэн 9 хоногт	олноор	605	дамжаа барьсан гавж нар гүйцэтгэмий

ЭХ СУРВАЛЖ СУДЛАЛ

15.	цагаан сарын Сахиус	хаврын тэргүүн сарын 13-нд	12	12	Их жас гүйцэтгэмий
16.	мөн Дүдвийн Сахиус	мөн сарын 15-нд	8	8	Дүдвийн жас гүйцэтгэмий
17.	жасаа Нүннай	хаврын тэргүүн сарын 13-аас эхлэн 3 өдөр	16	16	Их жас гүйцэтгэмий
18.	жасаа 15-ны хурал хэмээх уншлага	хаврын дунд сарын шинийн 3-аас эхлэн 16 хүртэл	олноор	225	Их жас гүйцэтгэмий
19.	Гавжийн дамжаа суух	хаврын дунд сарын 12-оос эхлэн 9 хоногт	олноор	506	гавж болох хүмүүс гүйцэтгэмий
20.	жоро (?) хэмээх уншлага	хаврын дунд сарын 21-ээс 30 хүртэл	220	90	Их жас гүйцэтгэмий
21.	жасаа сарын хурал хэмээх уншлага	хаврын сүүл сарын шинийн 2-оос эхлэн 30 хоногт	олноор	208	мөн Их жас
22.	Гавжийн дамжаа суух	хаврын сүүл сарын шинийн 1-ээс эхлэн 9 хоногт	олноор	415	гавж болох хүмүүс гүйцэтгэмий
23.	жасаа Ганжуур	зуны тэргүүн сарын шинийн 8-нд	олноор	425	Их жас гүйцэтгэмий
24.	жасаа хорийн(хорь хоног) хурал хэмээх уншлага	зуны тэргүүн сарын 17-оос эхлэн 20 хоногт	олноор	230	мөн Их жас
25.	Мэгзээний бүтээл, мөн Жанрайсэгийн бүтээлийн хамт	зуны дунд сарын шинийн 8-аас эхлэн 6 хоногт	олноор	525	Бүтээл жас гүйцэтгэмий
26.	жасаа сарын хурал хэмээх 30 хоногт	зуны дунд сарын 17-оос эхлэн 30 хоногт	олноор	158	Их жас гүйцэтгэмий
27.	Гавжийн дамжаа суух	зуны дунд сарын 17-оос эхлэн 9 хоногт	олноор	200	гавж болох хүмүүс гүйцэтгэмий
28.	Хүвэрийн сан хэмээх уншлага	зуны дунд сарын 19-нд	4	4	Их жас
29.	Жанрайсэгийн нүннай хурах	зуны дунд сарын 13-аас эхлэн 3 өдөр	16	16	мөн Их
30.	Гэндүндүйвийн хорол хурах Гавжийн дамжаа сууж	зуны сүүл сарын 19-нд	13	13	Их жас
		шинийн нэгнээс эхлэн 9 хоногт			
31.	намрын 1 сарын хурал хэмээх уншлага	намрын дунд сарын шинийн 3-аас эхлэн 30 хоногт	олноор	55	Их жас

32.	намрын Гавжийн дамжаа суух	намрын дунд сарын шинийн 3-аас эхлэн 9 хоногт	олноор	207	гавж болох хүмүүс гүйцэтгэмий
33.	жасаа Бизъяагын дончид хурах	сар бүрийн 15-нд	50	50	Их жас гүйцэтгэмий
34.	Дарь эхийн бүтээл уншлага	дервөн цагын дөрвөн өдөр	13	13	Их ба Дордүв Бүтээл Дүдвий жасууд гүйцэтгэсэн
35.	Түмэд хэмээх Сахиус	намрын дунд сарын 23-аас эхлэн 6 хоногт	100	50	Их жас гүйцэтгэсэн
36.	хорийн хурал хэмээх уншлага	намрын сүүл сарын 17-оос эхлэн 20 хоногт	олноор		Их жас гүйцэтгэсэн
37.	Жамбалын бумба Пунцалдомын (?) бумба хэмээх уншлага	намрын сүүл сарын 15 ба 16-нд	13		Их жас гүйцэтгэсэн
38.	олны их Сахиус	өвлийн тэргүүн сарын шинэ өдөр хурдаг	олноор		Их жас гүйцэтгэсэн
39.	жасаа арван тавны хэмээх хурал уншлага	өвлийн тэргүүн сарын 17-оос эхлэн 15 хоногт	олноор		Их жас гүйцэтгэсэн
40.	Их сахиусны дордүв хэмээх хурал уншлага	өвлийн тэргүүн сарын 15-аар 4 хоногт	13		Дордовын жас гүйцэтгэсэн
41.	Гүргулийн дордүв хэмээх хурлын уншлага	өвлийн тэргүүн сарын 20-оос мөн 4 хоногт	13		Гүргулийн жас гүйцэтгэсэн
42.	Гүнрэг хэмээх хурал уншлага	өвлийн тэргүүн сарын 22-нд нэг өдөр хурдаг	10		Гүнрэгийн жас гүйцэтгэсэн
<b>Идгаачойнзинлийн дацан</b>					
1.	Гүнчийчэнмогийн хурлын уншлага	өвлийн дунд сарын 17-оос эхлэн 30 хоногийн хугацаатай хурал	олноор	255	
2.	мөн хурлын дотор Парчин домын дамжаа суух	мөн сарын 22-ны өдрөөс эхлэн 6 хоног	олноор	344	
3.	жасаа Сахиусны уншлага	өдөр бүр	6	6	
4.	жасаа Цэдэвийн уншлага	өдөр бүрийн	1	1	
5.	жасын галын тахилга	өвлийн сүүл сарын 24-нд	2	2	
6.	Хуучин ном хэмээх Сахиус	өвлийн сүүл сарын 29-нд	50	30	

ЭХ СУРВАЛЖ СУДЛАЛ

7.	Цэдэрлхамын уншлага	өвлийн сүүл сарын 30-нд	50	50	
8.	Цагаан сарын Дүдний хэмээх уншлага	хаврын тэргүүн сарын шинийн нэгнээс эхлэн 15 хоногт	олноор	107	
9.	Гавжийн дамжаа суух	хаврын тэргүүн сарын 16-аас эхлэн 6 хоног	олноор	350	
10.	жасаа арван тавны хурал хэмээх уншлага	хаврын дунд сарын шинийн 3-аас эхлэн 16 хүртэл	олноор	157	
11.	Гавжийн дамжаа суух	хаврын дунд сарын 12-оос эхлэн 6 хоногт	олноор	324	
12.	Жор (?) хэмээх уншлага	хаврын дунд сарын 21-ээс эхлэн 30 хүртэл	110	43	
13.	жасаа сарын хурал хэмээх уншлага	хаврын сүүл сарын шинийн 2-оос эхлэн 30 хоногт	олноор	143	
14.	Гавжийн дамжаа суух	хаврын сүүл сарын шинийн нэгнээс эхлэн 6 хоногт	олноор	294	
15.	жасаа Санжид	зуны тэргүүн сарын 15-нд хурдаг	олноор	276	
16.	жасаа хорийн хурал хэмээх уншлага	зуны тэргүүн сарын 17-оос эхлэн 20 хоногт	олноор	314	
17.	Мэгзээний бүтээл, мөн Жанрайсэгийн бүтээл хамт	зуны дунд сарын шинийн 8-аас эхлэн 6 хоногт	олноор	314	
18.	жасаа сарын хурал хэмээх 30 хоногийн уншлага	зуны дунд сарын 17- оос эхлэн 30 хоногт	олноор	96	
19.	Гавжийн дамжаа суух	зуны дунд сарын 17- оос эхлэн 6 хоногт	олноор	113	
20.	Гавжийн дамжаа суух	зуны сүүл сарын шинийн 2-оос эхлэн 6 хоногт	олноор	107	
21.	жасын Намсрай ба Түгдүн (?) хурлын уншлага	мөн сард өдөр сонгож 1 өдөр хурдаг	12	12	
22.	Ядам сахиусны уншлага	мөн сард хурдаг	12	12	
23.	Гавжийн дамжаа суух	намрын дунд сарын шинийн 2-оос эхлэн 6 хоногт	олноор	120	
24.	Сарын хурал хэмээх уншлага	намрын дунд сарын шинийн 3-аас эхлэн 30 хоногт	олноор	78	

25.	Түмэд хэмээх хангал хурал	намрын дунд сарын 23-аас эхлэн 6 хоногт	50	50	
26.	хорийн хурал хэмээх уншлага (үүний дотор 22-ны дүйцэн хурмой)	намрын сүүл сарын 17-оос эхлэн 20 хоногт	олноор		
27.	Чойжил Намсрай сахиусны уншлага	өвлийн тэргүүн сард өдөр сонгож хурдаг	олноор		
28.	арван тавны хурал хэмээх уншлага	өвлийн тэргүүн сарын 17-оос эхлэн 15 хоногт	олноор		
	жич хойдын хурдаг хурал				
29.	Лянх домын уншлага	зуны сүүл сарын шинийн 3-аас эхлэн 2 өдөр	нэг зиндааны лам нарын хурал	14	
30.	Лхавав домын уншлага	намрын сүүл сарын 21-нд хурдаг, 2 өдөр	мөн		
31.	25-ны домын уншлага	өвлийн тэргүүн сарын 24-өөс эхлэн 2 өдөр хурдаг	мөн		
32.	Жүш/Зүш (?) хэмээх домын уншлага	өвлийн дунд сарын 13-аас эхлэн 2 өдөр хурдаг	мөн		
33.	19-ны домын уншлага	мөн сарын 19-нд хурдаг	мөн		
34.	20-ны домын уншлага	мөн сарын 20-нд хурдаг	мөн		
35.	21-ны домын уншлага	мөн сарын 21-нд хурдаг	мөн		
<b>Хайлан жас</b>					
1.	Жасын Цэдэв уншлага	өдөр бүр хурдаг	1	1	
2.	Яр хайлангийн уншлага	зуны сүүл сарын 15- аас эхлэн 45 хоногт	олноор	441	
3.	Жасаа Намсрайн уншлага	намрын дунд сард өдөр сонгож хурдаг	6	6	
<b>Эмч нарын дацан</b>					
1.	Жасаа тогтмол хурал	өдөр бүрийн	12	9	тасарсан хурал номгүй
2.	Дүйцэн ерөөл	хаврын тэргүүн сарын шинийн нэгнээс 15 хуртэл		28	
3.	Сахиус	сар бүрийн 15-нд		9	
4.	Сахиус	сар бүр 29-нд		9	

5.	Сожинтой Манал	сар бүрийн шинийн 8-нд		9	
6.	Яндаг сан (?)	сар бүрийн шинийн 2-нд		9	
7.	Долоон оточийн дончид	хаврын дунд сарын 16-нд		36	
8.	Маналын сачог дүлцэн дашгадан равнай. Сахиус	зуны тэргүүн сарын шинийн иэгнээс 17 хүртэл		73	
9.	Их Сахиус	зуны дунд сарын 15, 29-нд 2 өдөр		76	
10.	Дарь эхийн сачог дүлцэн дашгадан	зуны сүүл сард 15 өдөр	32	32	
11.	Гонгор Намсрай	зуны сүүл сарын 30- нд 1 өдөр	8	8	
12.	Маналын нүннай	зуны тэргүүн сард 15 өдөр	4	4	
13.	2 сахиусны түгдин/гүтэг (?)	намрын тэргүүн сард 1 өдөр	21	21	
14.	Сахиусны дордүв	өвлийн тэргүүн сард 4 өдөр	12	12	
15.	Магтаал	өвлийн сүүл сарын 15-нд 1 өдөр		78	
16.	Дүйцэн ерөөл	намрын сүүл сарын 22, өвлийн тэргүүн сарын 3, 18, 25 өвлийн дунд сарын 7, 12 өвлийн сүүл сарын 25-нд тус тус		10	
17.	Цэдэрлхам	өвлийн сүүл сарын 30-нд	30	30	
<b>Жадарын аймаг</b>					
1.	Магтаал гүйгээд (?) уншмой	өвлийн сүүл сарын 17-оос эхлэн 3 хоног хурмой	112	60	-
2.	Чойжоо дүгжүү	сар бүрийн 19-нд хурмой	4	4	-
3.	Цэдорлхам хурмой	өвлийн сүүл сарын 30-ны шөнө хурмой	112	71	-
4.	Жадар хурмой	сар бүрийн 10-нд хурмой	4	4	-
5.	Өндөр богдын дүйцэн хурмой	хаврын тэргүүн сарын 14-нд хурмой	112	33 (31?)	-

6.	8-р Богдын дүйцэн хурмой	зуны тэргүүн сарын 17-нд хурмой	112	18	-
7.	Бурхан багшийн дүйжүд хурмой	зуны сүүл сарын шинийн 4-нд хурмой	30	30	-
8.	Жадарын дулцэн хурмой	зуны дунд сарын 12-ны өдрөөс эхлэн 3 хоног хурмой	21	21	-
9.	Гонгор Намсрай хурдаг	зуны сүүл сарын 30- нд 1 өдөр хурмой	112	41	-
10.	Даншигийн хангал хурдаг	өвлийн дунд сарын шинийн 3-аас эхлэн 5 хоног хурмой			
<b>Тойсамлин аймаг</b>					
1.	Шаршин Чойжоо, Лхам, Намсрай	өдөр бүр	1	1	
2.	дүгжүү тугон (?)	сар бүр 29-нд	5	5	
3.	Гүнрэг	сар бүр 30-нд	4	4	
4.	Сандуй	сар бүрийн 15-нд	4	4	
5.	Галын тахилга	өвлийн адаг сарын 24-нд	4	4	
6.	10 хангал дүгжүү данрагтай	мөн сарын 29-нд нэг өдөр	олноор	20	
7.	Цэдэр Лхам данрагтай ерөөл цогломтой (?)	хаврын эхэн сарын шинийн нэгэнд 1 өдөр	олноор	70	
8.	Далхаг санжин (?)	мөн сарын шинийн 2-нд 1 өдөр	4	4	
9.	Ерөөл овuu маань нэг цогломтой	мөн сарын 14-нд 1 өдөр	10	10	
10.	Гонгорын бумба	дунд сарын 13-нд нэг өдөр	4	4	
11.	Лхамын дордүүв	мөн сард тогтмол өдөргүй 3 өдөр	13	13	
12.	цагийн магтаал овuu маань цоглом	мөн сард тогтмол бус 3 өдөр	олноор	67	
13.	Намсрайн бумба	зуны эхэн сарын 15- нд 1 өдөр	4	4	
14.	Гүнрэгийн дулцэн	зуны дунд сард тогтмол өдөр үгүй 7 хоног	37	17	
15.	Гонгорын бумба	мөн сарын 13-нд 1 өдөр	4	4	
16.	6 хангал данрагтай	зуны адаг сарын 28-нд 1 өдөр	10	10	

ЭХ СУРВАЛЖ СУДЛАЛ

17.	10 хангал шадар (?) дүгжүүтэй 2 данрагтай	мөн сарын 29-нд 1 өдөр	олноор	30	
18.	Гонгор Намсрай данрагтай Янжинмаа бүмчин лүндагчай (?) Далхаг санжин лам нар дөрөв дөрвөөр тасарч хурдаг	мөн сарын 30, 1 өдөр	олноор	37	
19.	Гонгорын бумба	намрын дунд сарын 13-нд 1 өдөр	4	4	
20.	Лхамын тээдүй (?) шадар (?) данраг цогчигтай (?)	мөн сарын 15-нд 1 өдөр	12	12	
21.	Өвлийн эхэн сарын 15-нд 4 хангал шадар (?) данрагтай	өвлийн эхэн сарын 15-нд 1 өдөр			
22.	10 хангал сүүл өдөр данрагтай	өвлийн дунд сарын 3-нд 3 өдөр			
23.	Гонгорын бумба	мөн сарын 13-нд 1 өдөр			

ЦЭЦЭН ТОЙНЫ АЙМАГ

1.	Жамсран сахиусны дордүв хурмой сан жас зузаатган буян хишиг арвигах тухай хурмой	өвлийн дунд сард жилд тогтмол өдөр үгүй нэг удаа 4 хоног	13	13	
2.	Сахиус довтай (довог?) хурмой аймаг олноор өвчин зовлонгүй байх тухай	өвлийн сүүл сард жилд тогтмол өдөр үгүй нэг удаа нэг өдөр хурмой	21	21	
3.	Жасын галын тэнгрийг тахимой сан жас зузаатгах гал бурхан ариутгах тухай	өвлийн (сүүл?) сарын 24-нд нэг өдөр	4	4	
4.	Сандуй жамдар (zonхор? жонхор?) ламын цогчидтой хурмой хувраг олныг ловнарын тухай	өвлийн сүүл сарын 25-нд нэг өдөр	8	8	
5.	2 дугаарын дайчод ерөөл хурмой мөн ачийг дурдан ерөөж тахимой	өвлийн сүүл сарын 27-нд нэг өдөр	олноор	21	
6.	Хуучин ном хэмээх Хангал уншиж мөн жил солихын завсарт олны барцад арилгах тухай	өвлийн сүүл сарын 29-нд нэг өдөр	20	20	
7.	Цэдэрлхам хурмой жилийн эхэнд Лхам бурхныг тахиж даатгаж буй	өвлийн сүүл сарын 30-нд нэг өдөр	олноор	олноор	
8.	Өндөр гэгээний Ерөөл хурмой мөн ачийг дурдан ерөөж тахимой	хаврын тэргүүн сарын 14-нд нэг өдөр	олноор	18	
9.	Магтаал хурмой урьд заларсан шашныг баригч дээдэс нарын ачийг дурдан магтан залбирмой	хаврын тэргүүн сард жилд тогтмол үгүй 3 хоног	олноор	олноор	

10.	Гомбо сахиусны дордүв суумой сан жас зузаатган буян хишиг арвитгах тухай	хаврын дунд сард жилд нэг удаа тогтмол өдөр үгүй 4 хоног	19	19	
11.	Маналын дончид хурмой олны өвчин барцадын тухай	зуны тэргүүн сарын 8-нд нэг өдөр	20	20	
12.	Бизъяагын дончид Найдан чоготой олны насыг уртатгах тухай	зуны тэргүүн сарын 15-нд нэг өдөр	20	20	
13.	Сандуйжамдарын (?) дүлцэн хурмой лам нарын ухаан ловнаар сайжрахын тухай	зуны дунд сард тогтмол өдөр үгүй нэг удаа 7 хоног	19	19	
14.	Миндугвийн дүлцэн хурмой хар шар олон амьтныг муюу заняанаас гэтлэх тухай	зуны сүүл сард тогтмол өдөр үгүй нэг удаа 7 хоног	13	13	
15.	Намсрайн сан хурмой сан жас арвитгах тухай	зуны сүүл сарын 15-нд нэг өдөр	олноор	олноор	
16.	Гонгор Намсрай хурмой мөн буян хишиг дуудаж амой	зуны сүүл сарын 30-нд	олноор	олноор	
17.	Гонгорын бумба хурмой буян хишиг дуудмой	намрын тэргүүн сард тогтмол өдөр үгүй нэг өдөр	4	4	
18.	Жанрайсэгийн нүннай сахимой олон амьтан хар шар нийтийн нүтэл хилэнц арилгах тухай	нармын сүүл сарын 20-оос эхлэн 3 хоног	4	4	
19.	Хоёр сахиус тахимой үйлс даатгаж барцад сахиулах тухай	өвлийн тэргүүн сард тогтмол өдөр үгүй нэг удаа	олноор	олноор	
20.	Даншигийн хангал хурмой нийт хар шар олон амьтны барцад сахиж амгалан гэтлэх тухай	өвлийн дунд сард тогтмол өдөр 4 хоног	олноор	олноор	
21.	Цагаан сахиус хурмой сан жасын эдийг хулгайд алдахгүйн тухай	өвлийн дунд сарын 12-нд нэг өдөр	12		
22.	Жасаа сахиус хурмой аймгийн дотор буй олон нийтийн барцад сахих тухай	өдөр бүр хурмой	2	2	
23.	Чойжүн (?) уншмой сан жас арвитгах тухай	өдөр бүр	1	1	
<b>Дашдандарлын аймаг</b>					
1.	Энэ аймгийн лам нарын биег өвчин зовлонгүй мэнд сайн суухын тухай Жамсран сахиус	өдөр бүр хурдаг	2 лам	2	
2.	Өөр өөрсдийг бурхан болохын замыг шулуун болгохын тухай Жамсрангийн дордүв хэмээх хурал	өвлийн сард өдөр сонгож 4 хоног хурдаг	12 лам	12	

ЭХ СУРВАЛЖ СУДЛАЛ

3.	өөр өөрсдийг түргэн бурхны хутгийг олох тухай Дагдан сэмбэрэм (?) хэмээх хурал	өвлийн сүүл сарын 25-нд багтаан хурдаг	4 лам	4	
4.	2-р Богдын дайчид хэмээх жасаа Ерөөл хэмээх хурал	өвлийн сүүл сарын 27-ны өдөр хурдаг	10 лам	10	
5.	өөр өөрсдийг бурхан болох замыг шулуун болгохын тухай ном Хуучин хэмээх хурал	өвлийн сүүл сарын 29-ний өдөр хурдаг	10 лам	10	
6.	өөр өөрсдийг нас урт болгохын тухай Цэдэрлхам хэмээх хурал	өвлийн сүүл сарын 30-ны шенөөс эхлэн Цагаан сарын 1-ний өглөө хүртэл хурдаг	аймгийн бүх лам	70	
7.	Өндөр бодгын дайчид хэмээж Ерөөл хурал	Цагаан сарын 14-ний өдөр хурдаг	10 лам	10	
8.	Бурхан бодисадын эрдмийг магтаж өөрсдийн буян хураахын тухай Магтаал хэмээх хурал	хаврын дунд сард өдөр сонгож 3 хоног хурдаг	аймгийн бүх лам	70	
9.	8-р Богдын дайчид хэмээж Ерөөл хурал	зуны эхэн сарын 17-ны өдөр хурдаг	10 лам	10	
10.	уг ёсоор өөрсдөө түргэн бурхан болохын төлөө дүлцэн хурал	зуны сард өдөр сонгож 15 хоног хурдаг	21 лам	21 лам	
11.	хоосон ядрахын зовлонгүй явахын тухай Гонгор Намсрай хэмээх хурал	зуны сүүл сарын 30-ны өдөр хурдаг	аймгийн бүх лам	50	
12.	өөрсд хоосон ядрахын зовлонгүй явах тухай Гонгорын бумба хэмээх хурал	намрын эхэн сард өдөр сонгож 1 хоног хурдаг	4 лам	4	
13.	өөрсд бурхан болохын замыг шулуун болгохын тухай намрын Түмэд хэмээх хурал	намрын сүүл сард өдөр сонгож 1 хоног хурдаг	аймгийн бүх лам		
14.	өөрсд бурхан болгохын замыг шулуун болгох тухайд Даншигийн хангал хэмээх хурал	өвлийн дунд сарын 3-аас эхлэн 3 хоног хурдаг	аймгийн бүх лам		
15.	өөрсд бурхан болох замыг шулуун болгох тухайд авралын Түмэд хэмээх хурал	өвлийн сард өдөр сонгож 1 хоног хурдаг	аймгийн бүх лам		
16.	өөрсд бурхан болох тухайд Цээжүүгийн чодов хэмээх хурал	намрын эхэн сарын арванд нэг өдөр хурдаг	4 лам	4	энэ хурдаг хурал бүхий олон нийтийн тусын тулд хурмой
	<b>Жасын аймаг</b>				

1. аймаг шавь нар өвчингүй суух тухай жасаа хурал	өдөр бүр хурмой	2	2	
2. мөн нэгэн адил Сахиус хурал Гүндамжүн (?)	сар бүрийн 2-нд хурмой	4	4	
3. бурхны үр (үйл?) зохиол зохиосон өдөр буяныг хураах тухай Ерөөл хурал	арван дөрвөнд Ерөөл хурмой	бүгд	8	
4. нас буян арвижих тухай Чойжоо дүгжүү	сар бүрийн 29-нд	4	4	
5. Бурхныг магтаж буян хурах тухай Магтаал хурал	хаврын дунд сард өдөр үзэж 7 өдөр хурмой	бүгд	15 орчим	
6. өөрсдийн бурхан болох шид бүтээх тухай Үндэс хурал Дамдингарвуу чого	мөн сард өдөр үзэж 2 өдөр хурмой	12	4	
7. элдэв өвчинеэс асрахын тухай Манал хэмээх хурал	зуны тэргүүн сарын 8-нд тогтмол нэг өдөр хурмой	8	8	
8. дээр дурдсан нэгэн адил Үндэс хурал	зуны дунд сард өдөр үзэж 2 өдөр хурмой	12	6 орчим	
9. Бурхан болохын мөрийг саадгүй тухай Чойжоо сахиус	мөн сарын 29-нд тогтмол нэг өдөр хурмой	бүгд	16 орчим	
10. амьтныг ядрах хоосрохоос хамгаалахын тухай Гонгор Намсрай хурал	зуны сүүл сарын 30-нд тогтмол нэг өдөр хурмой	бүгд	18 орчим	
11. амьтан өвчин зовлонгүй бурхны шашин магтаж тухай Манал Найдан хурал	зуны сард өдөр тогтмол үгүй нэг өдөр хурмой	бүгд	17	
12. дээр дурдсан адил Үндэс хэмээх хурал	намрын дунд сард өдөр тогтмол үгүй 3 өдөр хурмой	нэг өдөр 12 лам	6	
13. буян хураах тухай Үндэс хэмээх хурал	намрын сүүл сарын 15-нд тогтмол суумой	4		
14. бурхан болох шидийг бүтээлгэж хайлрах тухай Их сахиус хэмээх хурал Дамдин Сандув	өвлийн тэргүүн сард өдөр үзэж нэг өдөр хурмой	бүгд		
15. бурхан болохын сайн замын үйлс дэлгэрүүлэх тухай Хангал хэмээх хурал	өвлийн дунд сард тогтмол 4 өдөр хурмой	бүгд		
16. дээр дурдсан адил Үндэс хэмээх хурал	мөн сард тогтмол 2 өдөр хурмой	нэг өдөр 12 лам		
17. аймгийн шавь нарын мэнд суух тухай Түмэд хэмээх хурал	өвлийн сүүл сард өдөр үзэж нэг өдөр хурмой	бүгд		

ЭХ СУРВАЛЖ СУДЛАЛ

18.	нас буян арвижих тухай Дордүв хэмээх хурал	өвлийн сард өдөр үзэж 5 өдөр хурмой	12		
19.	дээр дурдсан адил Хуучин хэмээх хурал Хангал	өвлийн сүүл сарын 29-нд нэг өдөр хурмой	20		
20.	Лхам заларж зэрэгт нас буяныг бат болгох тухай Цэдэрлхам хэмээх хурал	мөн сарын 30-аас цагаан сарын нэгэн хүртэл хурмой	бүгд		
<b>Номчийн аймаг</b>					
1.	Хуучин ном хэмээх арван хангал хурмой	өвлийн сүүл сарын 29-нд нэг өдөр	10	10	Улаан сахиусны дордүв хэмээх хурал цөөхөн жил 15 ламаар хурж явсан боловч тэр нь гагцхүү сайд лам Лувсанбалдан дур сүсгээр өглөгийн эзэн болж хуруулж явсан агаад эдний гэр орон нэгэнт баригдаж баларсан учраас тасарсан болмой
2.	Цэдэрлхам	өвлийн сүүл сарын 30-ны шөнө дундаас шинийн нэгний өглөө хүртэл	олноор боловч	20	
3.	Өндөр гэгээний дүйцэн ерөөл	хаврын тэргүүн сарын арван дөрөвний орой	олноор боловч	11	
4.	Магтаал	хаврын тэргүүн ба дунд сард	олноор боловч	20	гаруй
5.	Жадар Шалш	хаврын сүүл сарын 8-нд нэг өдөр	10	10	
6.	Сожинтой Манал	зуны тэргүүн сарын шинийн 8-нд нэг өдөр	10	4	
7.	Мөнх маань	зуны сүүл сарын шинийн 4-нд нэг өдөр	олноор боловч	20	гаруй
8.	Гонгор Намсрай	зуны сүүл сарын 30-нд нэг өдөр	олноор боловч	30	гаруй
